ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ
Холбоо барих утас: 1800-1646, 7575-1111 /1376/
Цахим шуудан: investornews@golomtbank.com

“ГОЛОМТ БАНК” ХК-ИЙН 2026 ОНЫ 3-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН НИЙТЛЭГДЛЭЭ

Монгол улс, Улаанбаатар хот – (2026.10.19) “Голомт банк” ХК-ийн 2026 оны 3-р улирлын санхүүгийн тайлан нийтлэгдлээ.

2026 оны 3-р улирлын байдлаарх макро-эдийн засгийн үзүүлэлтүүд:

Монгол Улсын эдийн засаг 2026 оны эхний 8 сарын байдлаар 7.3 хувиар өсөж, сүүлийн 5 жилийн хамгийн өндөр өсөлтөд хүрээд байна. Энэхүү өсөлтийг уул уурхай болон тээврийн салбар голлон бүрдүүлж, нийт өсөлтийн 4.1 нэгж хувийг дангаараа бүрдүүлжээ. Харин уул уурхайн бус салбарууд болох худалдаа, үйлчилгээний өсөлт саарч байгаа нь өндөр инфляцын нөлөөгөөр өрхийн бодит орлого, худалдан авах чадвар суларч байгааг илтгэж байна.

Инфляцын түвшин мах, шатахууны үнийн өсөлтийн нөлөөгөөр 3-р улиралд эрчимжсэн ба 9-р сарын байдлаар жилийн инфляц 12.9%-д хүрчээ. Ийнхүү нийлүүлэлтийн гаралтай эрсдэлээс шалтгаалж инфляц эрчимжиж байгаа тул Төв банкны зүгээс 8-р сард бодлогын хүүг 12.5 хувьд хүргэж нэмэгдүүлсэн ба 9-р сарын хурлаар энэхүү түвшинг хэвээр хадгалсан. Ирэх саруудад Улсын төсвийн тодотголтой холбоотой төсвийн урсгал зарлага өсөхөөр хүлээгдэж байгаа нь эрэлтийн талын инфляц эрчимжих эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тиймээс Төв банкны зүгээс мөнгөний хатуу бодлого баримтлах үндсэн чиглэлтэй байна.

Уул уурхайн салбарын өсөлт нь нүүрс, зэс зэрэг голлох экспортын бүтээгдэхүүний эрэлт өндөр, экспортын хэмжээ тогтвортой байгаатай холбоотой байна. Тухайлбал, III улирлын байдлаар БНХАУ руу экспортолсон нүүрсний биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 41 хувиар өсөж 82.3 сая тоннд хүрсэн бол зэсийн экспортын дундаж үнэ 34 хувиар өсөж нэг тонн нь 3,598 ам.доллар болсон байна.

Эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 16.2 тэрбум ам.доллар, импорт 9.7 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 6.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Цаашид уул уурхайн үйлдвэрлэл өндөр түвшинд хадгалагдаж, томоохон дэд бүтцийн төслүүд үргэлжлэхийн хэрээр шатахуун, уул уурхайн тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн зориулалттай импортын эрэлт өндөр хэвээр байх төлөвтэй байна.

Экспортын орлого нэмэгдсэнээр гадаад валютын урсгал тогтвортой хадгалагдаж, 2026 оны 9-р сарын байдлаар гадаад валютын улсын албан нөөц 8.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 51 хувиар өсөөд байна.

Банкны секторын голлох үзүүлэлтийн хувьд мөнгөний нийлүүлэлт 8-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар өсөж, 54.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтийг төгрөгийн хадгаламж, харилцах дансны үлдэгдлийн өсөлт болон гадаад цэвэр активын хүчтэй тэлэлт дэмжжээ. Тухайлбал, гадаад цэвэр актив хоёр дахин өсөж 13.6 их наяд төгрөгт хүрсэн бол дотоод цэвэр актив 8.9 хувиар нэмэгдсэн байна.

Нийт зээлийн үлдэгдэл 2026 оны 8-р сарын байдлаар 48.4 их наяд төгрөгт хүрч, жилийн дүнгээр 14.3 хувиар өссөн байна. Зээлийн өсөлтийг бизнесийн зээл голлон дэмжиж, тус төрлийн зээл 17.8 хувиар нэмэгджээ. Харин хэрэглээний зээлийн өсөлт 4.7 хувь болж саарсан байна. Бодлогын хүү өндөр түвшинд хадгалагдаж, мөнгөний бодлого чангарч буй нөхцөлд ирэх улирлуудад зээлийн өсөлт аажмаар саарах төлөвтэй байна.

Холбоо барих утас: 1800-1646, 7575-1111 /1376/
Цахим шуудан: investornews@golomtbank.com

Голомт банкны 2026 оны 3-р улирлын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Нийт актив 4 их наяд төгрөг буюу 25.8%-аар өсөж 19.6 их наяд төгрөгт хүрэв.
- Нийт зээлийн багц 854 тэрбум төгрөг буюу 10.9%-аар өсөж, 8.7 их наяд төгрөгт хүрэв. Үүний 54%-ийг байгууллагын зээл, 46%-ийг иргэдийн зээл эзэлж байна.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.7%-тай байна.
- Харилцагчийн эх үүсвэр 1.7 их наяд төгрөг буюу 18.4%-аар өсөж 10.7 их наяд төгрөгт хүрэв.
- Хөрөнгө оруулалтын багц 78.6%-аар өсөж, 2.7 их наяд төгрөгт хүрэв.
- Нийт өөрийн хөрөнгө 24.5%-аар өсөж, 1.8 их наяд төгрөгт хүрэв.
- Татварын дараах цэвэр ашиг 227.8 тэрбум төгрөгт хүрч, жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 18.1%-тай гарлаа.
- Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллаж байна.

Тайлантай танилцахыг хүсвэл ЭНД дарж зочилно уу.

Банкны тухай нэмэлт мэдээллийг дараах сувгуудаар авах боломжтой:
www.golomtbank.com/investor-relations
| X: @golomtbank | LinkedIn: www.linkedin.com/company/golomtbank
| YouTube: www.youtube.com/golomtbank
| Facebook: www.facebook.com/Golomtbank